

**“ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ ЦАХИМ АРИЛЖАА”
СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР**

Зорилго: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хүрээнд “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2022” стандартад нийцсэн нүүрсний цахим арилжааг нээлттэй, ил тод, оролцогчдын тэгш эрхийг хангасан байдлаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох, арилжааны мэдээллийг худалдагч, худалдан авагч, бусад оролцогчдод бодитой, үнэн зөв, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Хүлээгдэж буй үр дүн: Хэлэлцүүлгээр цахим арилжаанд оролцогчдод биржийн болон нүүрсний арилжаатай холбоотой дүрэм журам, зааврыг танилцуулах, дуудлага арилжаанд хэрхэн оролцох, гэрээ хэлцэл хэрхэн байгуулах, төлбөр тооцооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, арилжааны системийг зөв хэрэглэж хэвшүүлэх, мэдлэг чадварыг олгож арилжаанд оролцоход бэлтгэгдэнэ.

Оролцогчид: УУХҮЯ-ны төлөөлөл, Экспортод гаргах нүүрсийг худалдан авах сонирхогч этгээд, арилжаанд оролцогчид, худалдагчид, арилжаа зохион байгуулагч.

Хугацаа: 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Зохион байгуулагдах газар: Премьер Туушин Зочид Буудлын Соёмбо танхим

Цаг	Сэдэв	Агуулга	Илтгэгч
09:00-09:30	Бүртгэл /онлайн аар оролцох оролцогчдыг бүртгэх/		
09:30-09:40	Нээлтийн ажиллагаа	Нээлтийн үг	Ж.Ганбаатар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
09:40-09:50		МХБ-ийн ерөнхий танилцуулга	Х.Алтай МХБ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал
09:50-10:00	Нүүрсний арилжааг зохицуулах журам, зааврын танилцуулга	Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журмын танилцуулга	Б.Бямбадагва Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөх
10:00-10:10		Экспортод гаргах нүүрсний арилжааны мэдээ мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэх талаар	Т.Хаш-Эрдэнэ /МХБ ТӨХК-Бизнес хөгжлийн газрын захирал/
10:10-10:20		Экспортод гаргах нүүрсний арилжаа зохион байгуулах зааврын танилцуулга	И.Жавхлан /МХБ ТӨК-ҮАГ-ын захирал/
10:20-10:30	Цайны завсарлага		
10:30-11:15	Панель хэлэлцүүлэг	Нүүрсний нээлттэй цахим арилжаа, худалдагч талын бодлого,	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК, Монголын хөрөнгийн бирж ТӨХК, ЭЗХЯ, Боомтын сэргэлтийн үндэсний хороо
11:15-12:30	Туршилтын цахим арилжаа хийх	<ul style="list-style-type: none"> Системд бүртгэл хийх, Туршилтын арилжаа зохион байгуулах 	Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК, Монголын хөрөнгийн бирж ТӨХК

- Жич:**
1. Хэлэлцүүлэг Хятад, Англи хэлний орчуулгатай явуулах,
 2. Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК-ийн харилцагчдад биечлэн оролцох урилга хүргэх,
 3. Онлайн аар оролцох нөхцлийг бүрдүүлэх,